

## ТҮҮХ, ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Түүхийн ухааны дэд эрдэмтэн

**Д. Цэдэв****МОНГОЛЫН АРДЫН АРМИЙН ТҮҮХИЙН  
ЯРУУ АЛДАРТ ХУУДАС**

Харийн түрэмгийлэгчид, юуны өмнө Хятадын булаан эзлэгчид, цагаантны дээрэмчдийн эсрэг ард түмний зэвсэгт бослогын бэлтгэлийг хангахад 1920 оноос эхлэн гарсан «Монголын үнэн» сонин үнэлж баршгүй их үүрэг гүйцэтгэсэн билээ. Манай хувьсгалт хэвлэлийн ууган «Монголын үнэн» сонин тэр үеийн дэлхий дахины байдал, олон улсын коммунист хөдөлгөөний тухай, Октябрийн социалист их хувьсгалын чөлөөлөгч үзэл санаа, Орос оронд Зөвлөлт засаг байгуулагдан тогтож бэхжсээр байсан тухай, колони орнуудад өрнөж байсан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тухай, монгол-зөвлөлтийн ард түмний ах дүүгийн зузаан найрамдлын тухай олон түмэнд хялбар ойлгогдохоор бичиж нийтэлсээр байжээ.

1919 оны сүүлчээр Монгол оронд «Хятад цэргүүд олноор орж ирж, хэмжээлшгүй гэмт муу үйл үйлдсэний хор уршгаар монгол орон дотор хууль журам алдагдан, туйлын их самуун цөв, сүйтгэл гарч, нутаг орон дүүрэн хятад харгисуудын цэргүүд, хуаз нар тархаж, баян, үгээгүү ялгалгүй цөмийг дээрэмдэх хүчирхийллээр хөнөөх байтугай, алах хядах аюул гарган байхын дээр ард түмний эрх чөлөө, амгалан ахуй байдлыг олгохыг хүсэгч монголын үнэн сайн хүн нарыг барин авч, хятадын хэрцгий зандалчны цуст саварт тэд нар нь нэн их эрүү үзэн зовож, зарим нь тэсэлгүй нас барсан байна» гэх зэргээр тэр үеийн монголын ард түмний байдал хүнд бэрх, хувьсгалч эх орончдыг хатуу мөрдөж алан хядаж байсныг монголын ард түмэнд үнэн зөвөөр ухуулан таниулаад энэхүү хүнд байдлаас гарах арга замыг тодорхойлохдоо: «гадаадын шунахай эзэрхэгүүдээр эзлэгдэн дарлагдаж байсан монгол язгууртан нь ...эзлэн дарлагч дайсан лугаа тэмцэлдэж эрх мэдлээ байлдан авч, эд эрдэм дор боловсрон язгуур үндсээ бадруулан, олон нийтээр сайжрахын чөлөө учралт цаг ирсэн тул энэхүү их хэрэг үйлийг яахан бүтээвээс зохих учир мөрийг (арга замыг) энэ «монголын үнэн» хэмээх сэтгүүлд илтгэн гаргаж тунхаглан монголчуудад мэдүүлэн чин баатар зориг оруулж уул үндэсний улс төр байгуулах ба ард бүгдээр боловсрон хүмүүжихийн явдалд хөтөлбөр болгосугай хэмээн хичээн эрмэлзэнэ» гэх зэргээр тайлбарлан бичиж байжээ.

Д.Сүхбаатар, Х. Чойбалсан тэргүүтэй монголын хувьсгалчид «Монголын үнэн» сонины хуудсаар дамжуулан «...одоогийн чөлөө учралт цагт гадаадын харгисуудын нөлөөнд байгаа монгол язгуурын олон ард нь дэлхий дахины их улс нарын дарлагдсан ард түмэн ба олон язгуурын бага улсууд лугаа санал хүчээ хамтруулан хөдлөлцөж, эрх мэдлээ өөрсдийн гэрт авч, язгуур үндсээ бадруулан гадаад лугаа адил эрдэм соёлыг дэгжүүлэн боловсрохын тул нэгэн санаа нийтийн хүчээр идэвхтэй зүтгэмжлэн оролцох цаг болов: Хятадын эзэрхэг шунахай зарц Чэнь И нарт...битгий итгэгтүн! Тэдний захиа зарлигийг хэрэгсэн бүтээлгүй орхигтун! Алба татварыг битгий төлөгтүн! Өртөө зэргийн алба явуулахыг зогсон хаяцгааг-

тун! Тэднээр улс төрөө боловсруулсугай (удирдуулсугай) гэвэл мал сүргээ чоноор мануулан өсгөсүгэй гэсэнтэй адил бишүү» гэж уриалж байжээ.

Монголын хувьсгалчид ард түмнийг зэвсэгт тэмцэлд бэлтгэж «..ганц хүн мэт нэгмөсөн босож уул үндсэн монголын их хэрэг яруу алдар, чөлөө эрхийг хамгаалан эгүүлэхийг хичээн зүтгэмжлэхэд...зүй нь монгол олон өөрсдөө зориг хүчээ хамтатгаж, элсэн босож, цэрэг хуримтлуулан, зэр зэвсэг барьж ов мэхтэй, хорон бодлогот хятадын эзэрхэг шунахай дээрэмчдийг хөөн арилгаж, эрх чөлөөгөө эгүүлэн бадруулах аваас монгол улс нь гашуун зовлонгоос гэтэлж, амгалан жаргалангаар оршин, ашиг үйлдвэр, ахуй байдал нь боловсрон дэлгэрэх болно. Эрх чөлөө, засаг мэдлээ эгүүлэн мандуулахын тулд байлдан тэмцэхэд...хүчээ бэлтгэх» нь чухал хэмээн уриалаад «Монголчууд та нарт тус хүргэх нөхөд ойр, Умар зүгээс Зөвлөлт Оросын ардууд даруй ирнэ. Манай мандах замыг таслахыг хүсэгч мангас мэт харгис хятад эзэрхэгчүүдийг илд мэсийн хүчээр эс хөөвөөс язгуур монгол улсын жаргах явдал хаврын цасан мэт хайлан хоцрох биш үү» гэж монголын бүх ард түмэнд анхааруулж, тэднийг хувьсгалт тэмцэлд зоригжуулан зохион байгуулсаар байжээ.

Манай орон даяар эрх чөлөөний хөдөлгөөн өрнөж байсан үеийн дундуур 1921 оны гуравдугаар сарын 1-3-нд Монгол-Зөвлөлтийн хилийн зааг газар болох Троицкосавск (1934 оноос Хиагт гэж нэрлэгдэх болсон) хотноо хуралдсан МАХН-ын анхдугаар их хурлаар боловсруулан баталсан Монгол Ардын Намаас түмэнд тунхаглан зарлах бичиг» хэмээх нэртэй анхны Программд гадаадын ноёрхлоос улс орноо чөлөөлөн төрийн тусгаар тогтнолыг байлдан авч засгийн эрхийг ард түмний гарт шилжүүлэх зорилтыг дэвшүүлэн тавьжээ. Тэр чухал баримт бичигт хятадын түрэмгийлэгчид 1919 онд «цэргийн хүчээр түрэн орж ирээд, мөнхүү монгол улсыг хятадын колони болгож, үүрд мөлжин ашигласугай хэмээн харгис ширүүнээр манай монголын үндсийг балруулан, Монголын буй бүхий ашиг орлогын зүйлүүдийг хамран (булаан) авч эзэрхэн түрэмгийлсэн нь нүдний өмнө үзэгдсээр тул юун өгүүлнэ»<sup>1</sup> гэж заагаад одоо даруй хятадын харгис мэдлээс ангижирч, сая мөхсөн Монголын төрийг дахин шинэчлэн босгохыг зорино гэж уриалан дууджээ.

Домогт баатар, ухаан ихтэй жанжин Д.Сүхбаатарын удирдлагын дор Монгол Ардын журамт цэргийн дайчид Хиагт хотод бугшиж байсан хятадын үй түмэн гамин цэргийг 1921 оны гуравдугаар сарын 18-нд бутцохиж ардын хувьсгалын анхны том ялалт байгуулсан юм. Дараа нь Монгол Ардын журамт цэргийн өмнө, монгол орны үлэмж хэсгийг эзэлж өөрийн харгис дэглэмийг тогтоож, манай ард түмэнд хүнд зовлон учруулж байсан оросын цагаантны дээрэмчдийг устган дарах зорилго тавигджээ.

Монголын Ардын Түр Засгийн Газар цагаантны эсрэг байлдан тэмцэхэд цэргийн тусламж үзүүлэхийг Зөвлөлт Орос Улсын Засгийн газарт хандаж 1921 оны дөрөвдүгээр сард хүссэн бөгөөд тэр хүсэлтийг ёсоор болгож Улаан Армийн салбар ангиудаас бүрэлдсэн аялан байлдах корпус цэрэг хүрэлцэн ирж монголын ард түмэнд эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөний ариун тэмцэлд нь ах дүүгийн тусламж үзүүлсэн юм. Монгол-Зөвлөлтийн цэргийн дайчид цагаантныг бут цохиход хатан зориг гарган баатарлагаар тулалдан тус улсын нутгийн Умар, Төв хэсэгт, Өрнөт, Дорнод хязгаарт монгол-зөвлөлтийн ард түмний нийтийн дайсан цагаан гвардийнхны эсрэг мөр зэрэгцэн тэмцсэн юм. Энэ ширүүн тэмцлийн гал дунд манай хоёр ард түмэн, армиудын ах дүүгийн найрамдал, дайчин холбоо бүрэлдэн тогтож, манай ард түмнүүдийн шилдэг хөвгүүдийн асгаруулсан ариун цусаар мөнхөд гагнагдсан юм.

<sup>1</sup>Монгол Ардын Хувьсгалт Намын Программ, дүрэм. УБ., 1980. 45-р тал.

<sup>2</sup>Мөн тэнд. 47 тал.

1921 оны долдугаар сарын 6-нд монгол, зөвлөлтийн цэргийн түрүүчийн ангиуд Нийслэл хүрээг (одоо Улаанбаатар) чөлөөлж, 8-нд Монгол Ардын Намын Төв Хороо, Ардын Түр засгийн газар 315 пүү ачаа, зэвсгийг 12 морин тэрэг, 20 тэмээнд ачсаар Нийслэл хүрээнд шилжин иржээ. Долдугаар сарын 11-нд Ардын байнгын засгийн газар байгуулагдсанаар төрийн эрх хөдөлмөрчин ардын гарт шилжиж, тусгаар тогтносон бүрэн эрхт хувьсгалт Монгол улсыг тунхаглан зарласан бөгөөд тэр өдрөөс эхлэн жил бүр долдугаар сарын 11-нийг Ардын Хувьсгал ялсан үндэсний баярын өдөр болгон тэмдэглэдэг болсон билээ. Ардын хувьсгалын ялалт нь монголын ард түмэнд улс орноо нийгмийн дэвшлийн замаар хөгжүүлэх хэтийн өргөн төлөвийг нээн өгчээ. «Монгол Ардын Хувьсгалт Нам байгуулагдсаны 60 жилийн ойн тухай» МАХН-ын Төв Хорооны тогтоолд: МАХН нь монгол орны амьдралд үндсэн эргэлт гаргасан 1921 оны Ардын хувьсгалын ялалтыг удирдан зохион байгуулсан, улс орноо капиталист биш замаар хөгжүүлэх жанжин шугам, гурван удаагийн программдаа тодорхойлсон нийгэм-эдийн засгийн зорилгыг тууштай хэрэгжүүлж чадсаныг дүгнээд одоо үед дөрөв дэх программдаа тус оронд социализм байгуулж дуусгах цогцолбор зорилтыг тодорхойлон хэрэгжүүлж байгаагаа цохон заажээ.

1921 оны гуравдугаар сарын 18-ны тэр алдарт өдрөөс хойш манай арми орчин үеийн хүчирхэг арми болтлоо туулж өнгөрсөн тэмцэл ялалтын яруу алдарт замналын тухай монголын түүхчид, зохиолчид, уран зураачид, барималчид, хөгжмийн зохиолчид, уран шүлэгчдээс олон тооны зохиол бүтээл, зураг, баримал, хөшөө дурсгал, уран шүлэг, хөгжим, ая дуу бүтээж туурвисан юм.

МАН-ийн дайчин замлалын түүхэнд холбогдох ном зохиолоос зарим нэгийг нэрлэе. Юуны өмнө Хорлоогийн Чойбалсан, Дарьзавын Лосол, Гэлэгдоржийн Дэмид нарын зохиосон «Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх» (УБ. , 1934)-ийг нэрлэх хэрэгтэй байна. Энэ зохиол нь түүхэн дурсамжийн хэлбэртэй бичигдсэн зохиол юм. Ном зохиогчид 1921 оны ардын хувьсгалын хөдөлгөөний үйл хэрэгт эхнээс нь дуустал биеэр оролцож явсан болохоор болсон үйл явдал, үзэж харсан зүйлээ дурсан бичээд, зохих дүгнэлт хийж, тухайн үйл явдалд холбогдолтой баримт бичиг өргөн хэрэглэснээрээ тэдний зохиол их үнэ цэнэтэй, манай армийн түүхийг судлахад одоо ч ач холбогдолтой хэвээр байна.

Зохиогчид Монгол Ардын журамт цэргийг анх хэрхэн зохион байгуулж, хороо ангийн зохион байгуулалт хийсэн, хятадын гамин, оросын цагаантны эсрэг хийсэн байлдааны тухай, Д.Сүхбаатарын уран авьяас, монгол зөвлөлтийн цэргийн хамтын ажиллагааны эх үүсвэр зэрэг олон чухал үйл явдлыг энэ зохиолд дэлгэрэнгүй бичсэн юм.

Зохиогчид энэ номд 1919 оны сүүлчээр тус оронд хятад цэргүүд олноор орж ирж, харгис дэглэм тогтоож байсан, түүнийг монгол даяар үзэн ядаж байсан тухай бичсэнээс зарим мөрийг одоо хэвээр нь дурдахад сонин байна.

«Хятад харгис түшмэл ба гамин цэргүүд газар дэлхий дээр багташгүй, ямар ч ёсонд харшсан бузар муухай аюултай догшин түрэмгий агуулж... Монголын төв нийслэлээс эхлэн зах тойрон бүхий олон бага хот, хөдөөгийн номхон ардыг энэчилэнгээр дарлаж сүйтгэсэн аюулыг цаас харандаагаар бичээд барахгүй ажээ. Иймд бидний Монгол Улс, хэзээд харгис хятадын дарлалыг занаж тэмдэглэлтэй байнам гээд цааш нь Хятадын догшин хэрцгийг өшөөд хэлсэн хүний үгийг шүлэглэн бичсэн нь:

Хэрцгий харгис гамин хятад  
Хэргийг үүсгэж түүвээх нь  
Хэдэр сармагчин мэт аюултай.  
Харин ч түүнийг хага бутарган агнасан  
Хавтгай баатар Сүхбаатарыг  
Хамаг олноор биширнэ.  
Үнэгэн аргат, барсын сэтгэлт  
Өнөөх гамингууд маань үхэлд орсон чонотой адил  
Өлбөрөн гуйланчилж зугтав уу?  
Ээ гэгээ та нар чинь ингэж сөнөдөг юм санжээ!  
Бүү үзэгд, бүү харагд!  
Хэзээд энэ мэт үнэсэн товрог болтугай!<sup>1</sup> гэжээ.

Хятадын их гүрний дээрэнгүй үзэлтэн, үндсэрхэгчид, түрэмгийлэх, жанжлах үзэлтнүүд одоо ч 60 жилийн өмнөхтэй л адил хэвээрээ байна. Манай ахмад үеийнхэн тэднийг эрс жигшин үзэж байсан нь одоо ч хүчин төгөлдөр, бидэнд түүхийн сургамж болсоор л байна.

МАН-ийн түүхэнд холбогдох өөр олон тооны ном, зохиол байдаг. Үүнд: 1921 оны намар цагаан гвардынхны 42 хоногийн бүслэлтийг баатарлагаар тэсвэрлэн давж гарсан тухай өгүүлсэн «Толбо нуур» тууж (1925), Хиагтыг гамингаас чөлөөлсөн тухай найруулга (1924), Г. Дэмидийн зохиосон «Монгол ардын хувьсгалт улаан цэргийн хөгжсөн түүх» (1931), 1921 оны ардын журамт цэргийн дурдатгалууд (1961, 1968), 1939, 1945 оны байлдаанд оролцогч монгол, зөвлөлтийн ахмад дайчдын дурдатгалууд, Л. Тойв зохиож 1946 онд хэвлэгдсэн «Монгол ардын хувьсгалт цэрэг» 1921 оны ардын хувьсгалд оролцсон оросын хувьсгалчдад зориулан С. Дашийн бичсэн «Монгол түмний төлөө зүтгэсэн анд нөхөд» (1967), Ш. Жамсранжавын «БНМАУ-ын баатарууд» (1972), эх орны соргог манаа, энх хөдөлмөрийн мөнхийн харуул болсон хилчдийн тухай бичсэн Хилчид өгүүлж байна» (1973), зэрэг ном зохиолыг нэрлэж болно.

1971 онд хэсэг зохиолчдын бичиж хэвлүүлсэн «МАН-ийн 50 жил номыг зориуд дурдууштай байна. МАН-ийн түүхээр сүүлийн жилүүдэд гарсан ном зохиолоос генерал Б. Доржийн «Энхийн манаа», Ёндондүйчирийн «МАН-ийн доторхи нам улс төрийн байгууллага», «1921-1945 оны үеийн МАХЦ-ын түүхэнд холбогдох бичиг баримтуудын эмхтгэл» зэргийг нэрлэж болно.

Манай армийн ахмад дайчид С.Батаа, Д.Эрэндоо, Ж.Лхагвасүрэн, Г.Самдангэлэг, улсын баатар Д.Дандар, Д.Нянтайсүрэн нарын зэрэг олон хүмүүсийн бичсэн дурсамж зохиол бүтээлүүд гарчээ. Цэргийн сэдвээр маршал Ю.Цэдэнбалын хийсэн илтгэл, бичсэн өгүүлэл, хэлсэн үгийн эмхтгэл 1978 онд «Эх орноо батлан хамгаалахын төлөө» нэртэйгээр хэвлэгдсэн байна.

Зөвлөлтийн түүхч эрдэмтэд МАН-ийн түүхийг судалж, сонирхолтой номууд бичсээр байдаг юм. Үүнд: И.И.Кузнецов, Г.К.Плотников, Н.С.Шишкин, М.В.Новиков, Н.С.Соркин, Ю.О.Оглаев болон бусад олон хүнийг нэрлэж болно. Дэлхийн II дайны түүхийн 12 боть бүрэн зохиолд зөвлөлтийн түүхчид БНМАУ, түүний ардын армийн тухай дэлгэрэнгүй оруулжээ.

Зөвлөлтийн цэргийн нэрт зүтгэлтэн, гарамгай жанжин С.М.Буденный, А.М.Василевский, Г.К.Жуков, Рокоссовский, Яковлев, И.А.Плиев, В.А.Судец нарын дурдатгалууд, зохиол монгол хэл дээр хэвлэгдэж манай ун-

шигчдын сонирхолыг татсаар байдаг билээ. Монгол, зөвлөлтийн армийн найрамдал, дайчин холбоо гуйвалтгүй бэхжиж улам гүнзгийрсээр байна. Тэр нь ч зүй ёсны хэрэг бөгөөд учир нь манай хоёр арми адил зорилготой, зэвсэг нэгтэй, цэргийн тухай нэг шинжлэх ухааныг удирдлага болгож байдаг юм.

Монгол, зөвлөлтийн ард түмний дайчин нөхөрлөлийн түүхийг өгүүлсэн манай хоёр орны түүхчдийн бүтээж буй зохиол удахгүй хэвлэгдэн гарахаар бэлтгэгдэж байгаа нь их баяртай явдал мөн.

МАН-ийн түүхийг боловсруулахад чухал ач холбогдолтой баримт бичгүүд манай улсын архивуудад хадгалагдаж байдаг юм. Энэ далимд хэлэхэд манай нам, төр, цэргийн ахмад зүтгэлтэн нар хятадын эрх баригчдын их гүрний жанжлах, эзлэн түрэмгийлэх бодлогыг эрс буруушааж илчилсээр байсан олон баримт бий. Үүнээс зарим нэгийг жишээ болгож иш татахад: Одоогоос 57 жилийн өмнө 1924 онд Бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч Элбэгдорж, цэргийн яамны сайд С. Магсаржав, цэргийн зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Нанагдорж нарын гарын үсэгтэй гарсан 13-р тушаалд: «...Эрт урдаас монголын уудам нутагт эзэрхэн ард түмнийг дарлаж өөрийн ашгийг дэлгэрүүлж амташсан Хятадын харгисууд дахин монголыг эзлэн авч хуучин хэвээр мөлжин дарлахыг одоо хүртэл хичээн байна. Хянаваас Тэдгээр улс лугаа ямарч гэрээ найрамдал тогтоовч тийнхүү Монголыг эзэрхэн залгих санаагаа ямагт орхихгүй бизээ. Энэ мэтийн эзэрхэг этгээд нар манай Монгол улсын зүүн, баруун, өмнө гурван талд хил нийлэх бөгөөд умарт зүгт зөвлөлийн засагт холбоот улс хил залгасан нь бусад эзэрхэг улс лугаа адил биш. Харин манай олон түмэн ардын зовлон зүдгүүрийг мэдэх учир монгол ардыг эзэрхэгийн саварт оруулахгүйг хүснээ. Үүнийг маийа улсын харьяат үнэнч хэн хүн хэзээ ч умартахгүй биз ээ»<sup>1</sup> гэж онцлон тэмдэглэж байжээ.

**Д. Цэдэв**

кандидат исторических наук

## ОБ ИССЛЕДОВАНИИ ИСТОРИИ МОНГОЛЬСКОЙ НАРОДНОЙ АРМИИ

### (Резюме)

Статья посвящена 60-летию юбилею Монгольской Народной Армии, которая, пройдя путь борьбы и побед, превратилась в современную армию надежно стоящую на страже завоеваний народной революции 1921 г.

Остановившись на вопросе об исследовании истории МНА, автор отмечает боевую славу МНА и дает обзор литературы по истории МНА с ее кратким анализом.

Автор отмечает о том, какую исключительно важную роль в формировании МНА, сыграла газета «Монголын үнэн». Монгольские революционеры обращались со страниц этой газеты к народу с боевым призывом встать на решительную борьбу с иноземными захватчиками с помощью и при поддержке народов Советской России.

<sup>1</sup>БНМАУ-ын зэвсэгт хүчний архив. ф—1, Т—3, х/н 75.

Автор подчеркивает, что дружба и сотрудничество монгольской и советской армий неуклонно развиваются и углубляются, ибо у МНА и Советской Армии общие задачи, единое вооружение, одна военная наука. Подтверждением этому является совместный труд советских и монгольских историков о монголо-советском боевом содружестве, охватывающий весь период с. 1921 г. по сей день, который выйдет в свет в этом году.

В заключение автор анализирует некоторые архивные документы, в которых еще 50-60 лет назад гневно разоблачались великодержавные захватнические устремления китайских экспансионистов в отношении МНР.